

## МОНГОЛ-ЯПОНЫ ХУДАЛДАА, ЭДИЙН ЗАСГИЙН ХАРИЛЦАА

*А.Буянтөгс\**

Монгол-Японы хооронд дипломат харилцаа 1972 оны 2 дугаар сарын 24-нд тогтоосны 30 жилийн ой болж байна. Эхний 20-иод жилд хоёр орны нийгмийн байгуулал, үзэл суртал өөр, дэлхийн хоёр системийн зөрчилтэй хурц үе байсан ч гэсэн Монгол-Японы харилцаа 1990 оныг хүртэл хэвийн тогтвортой, салбаруудын харилцааны эхлэл аажмаар тавигдаж ирсэн билээ.

Ялангуяа 1990-ээд онд Монгол оронд ардчилсан хувьсгал өрнөж, өөрчлөлт, шинэчлэлт хийж эхэлснээс хойш Монгол-Японы харилцаа хоёр талын хүсэл эрмэлзлийн дагуу бүхий л салбаруудаар эрчимтэй өргөжин хөгжиж өнөөдөр итгэмжилсэн түншлэлийн хэмжээнд явагдаж байгааг энэ түүхт ойн үеэр тэмдэглэхэд таатай байна.

Монгол-Японы хооронд анх 1957 онд харилцан эрх тэгш, бие биеэ хүндэтгэх, харилцан ашигтай байх зарчмын үндсэн дээр худалдаа хийх хоёр талын мэдэгдэл гарч, худалдааны харилцаа эхэлжээ. Үүнд:

Японы Марубенийн охин компани “Ито”-гийн урилгаар Монголоос анх удаа худалдааны төлөөлөгчөөр МАХН-ын Төв Хорооны ажилтан Ө.Дорж, худалдааны танхимын ажилтан Н. Чулуунбат нар 1959 оны 5 дугаар сард Японы Токио хотноо зохиосон олон улсын яармагт оролцож, Японы үйлдвэр, худалдаа эрхлэгчидтэй танилцаж, Монголын тухай Японы худалдаа үйлдвэрийнхэнд хэвлэлийн бага хурал хийлгэж, түүнд худалдаа, үйлдвэрийн 1000-аад, хэвлэл мэдээллийн 300-гаад хүмүүс оролцож, тэдний сонирхсон асуултад дэлгэрэнгүй хариулт өгч, Японы олон улсын ба ЗХУ, дорнод европын орнуудтай худалдаа хийдэг Нийгэмлэгийн Ерөнхийлөгч ноён Ямамототой уулзаж Монгол-Японы хооронд худалдааны харилцаа тогтоох, худалдааны төлөөлөгч солилцох зэрэг асуудлаар санал солилцож, Японы худалдааны төлөөлөгчийг Монголд очихыг урьжээ.

\* А.Буянтөгс - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, доктор (Ph.D)

Манай Гадаад худалдааны яамны урилгаар Японы худалдааны болон олон улсын худалдааг дэмжих Японы нийгэмлэгийн төлөөлөгчид 1959 оны 7 дугаар сарын сүүлчээр монголд ирж хэлэлцээ хийж, Японы олон улсын худалдаа дэмжих нийгэмлэгтэй 1960 онд бараа харилцан нийлүүлэх тухай анхны Протоколд гарын үсэг зурснаар Монгол-Японы хоорондын худалдааны эхлэл тавигджээ.

1961 оны 4 дүгээр сард Японы Токио хотноо зохиогдсон олон улсын хаврын яармагт Ө. Дорж, Д. Цэрэнсанжаа, Юмжаа, Сагараажав нарын бүрэлдэхүүнтэй монголын худалдааны хоёр дахь төлөөлөгчид оролцож, Киото, Нара, Осака хотоор зочлон олон улсын үйлдвэр, худалдааны хүмүүстэй учирч, худалдаа хөгжүүлэх яриа хэлэлцээ хийж, ноолуурын үйлдвэр үзэж, энэ яармагийн үеэр Японы Бриджестон үйлдвэрийн захирал ноён Иномото-той уулзаж автомашины дугуй, өөр нэг пүүсээс модны үйлдвэрийн зарим төхөөрөмж худалдан авч, оронд нь ямааны ноолуур нийлүүлэхээр гэрээ байгуулсан байна.

Дээрх Протоколын дагуу 1960-1980 онуудад Монголэкспорт, Разноимпорт, Техноимпорт, Автонефтьимпорт, Монголимпекс зэрэг манай гадаад худалдааны нэгдлүүд, Японы худалдаа, үйлдвэрийн Вакокоэки, Ониша энд Кен, Тохобуссан, Номура трейдинг, Сонин, Бриджестон, Ёкохама Гому Сакай энд Сонз, Маякава, Хаяши Кашмир, Нише-Иваи, Тоёобоши, Фужи Кеори, Ямаки трейдинг, Санко Сейко, Иточу, Марубени, Сумитомо зэрэг олон пүүс, компаниудтай худалдаа хийж нийт 18,4 сая ам.долларын гүйлгээ хийсний дотор Монголоос адууны дэл, сүүл, ангийн үс, хурга, ишигний арьс, ямааны ноолуур, хялгас, үхрийн хөөвөр, эмийн ургамал, малын яс, ноолууран цамц зэрэг бараа экспортлож, Японоос автомашины дугуй, магнитофон, транзистор, тооны машин зэрэг электрон болон цахилгаан бараа, торгон ба ноосон даавуу, биеийн тамирын хувцас, хэрэглэл, эмнэлгийн багаж төхөөрөмж, хувилах машин, жижиг цахилгаан үүсгүүр, ноолуурын үйлдвэрийн сэлбэг хэрэгсэл зэргийг импортоор авсан байна.

Худалдааны яриа хэлэлцээг Монголын талаас Худалдааны танхим, Японы талаас ЗХУ, Зүүн европын орнуудтай худалдаа хийдэг нийгэмлэг зохион байгуулж жил бүр Улаанбаатар, Токиод ээлжлэн явуулдаг заншилтай болжээ.

1972 онд Монгол-Японы хооронд дипломат харилцаа

тогтоосны дараа худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг дэмжих зорилгоор талууд Монгол-Японы эдийн засгийн комисс, Япон-Монголын эдийн засгийн хороог үүсгэн байгуулсан байна.

Монгол-Японы эдийн засгийн комиссын анхны даргаар Гадаад худалдааны яамны нэгдүгээр орлогч сайд Ө. Дорж, орлогчоор нь Улсын төлөвлөгөөний комиссын худалдааны хэлтсийн дарга Бадамдорж, гишүүдээр Гадаад явдлын яамны Ази, алс дорнодын хэлтсийн дарга Цэрэнцоодол, Сангийн яамны Орлогын газрын дарга Баянбат, Геологи, уул уурхайн үйлдвэрийн яамны орлогч сайд Хурц, комиссын нарийн бичгийн даргаар Гадаад худалдааны яамны ажилтан Л. Насанбуян нар томилогджээ.

Японы тал Япон-Монголын эдийн засгийн хороог 20 гишүүнтэй байгуулж, түүнд Японы Хар төмөрлөгийн ассоциаци, Өнгөт металлын ассоциаци, Мицүи, Мицүбиши, Марубени, Сумитомо, Иточу зэрэг томоохон пүүс, компаниуд орсон байлаа.

Ө. Дорж нь Монголын худалдааны танхимын тэргүүлэгч гишүүн байсан тул Худалдааны танхимын нэрийн өмнөөс ЗХУ болон Дорнод европын орнуудтай худалдаа хөгжүүлэх Японы нийгэмлэгийн Ерөнхийлөгч ноён Х. Хондо, ноён Хорио, Ерөнхий захирал ноён Я. Хаяши болон бусад пүүс, компаний хүмүүстэй удаа дараа хэлэлцээ хийж худалдаа хөгжүүлэх, дайнтай байдлыг халж эдийн засгийн хамтын ажиллагааг өргөн хөгжүүлэх, Японы хөрөнгө оруулалтын чиглэлээр ярилцах үед хоёр талын сонирхсон гол сэдэв нь: тэмээний ноос, ямааны ноолуур боловсруулах үйлдвэр, Цагаан суваргын зэс, молибдены орд, Таван толгойн коксжих нүүрс, адууны мах боловсруулах, зочид буудал, хуурай зайны үйлдвэр барих, дайны төлбөрийн 80 сая ам.доллар, японы талаас хөнгөлөлттэй нөхцөлөөр 2 тэрбум 600 сая ам.долларын хөрөнгө оруулах зээл тусламж зэрэг асуудлууд яригдаж байжээ. Энэхүү хэлэлцээ нь манай талаас хаалттай нөхцөлд явагдаж байсан боловч Японы томоохон компаниуд оролцож, манай талтай хийж байгаа хэлэлцээний тухай Японы төвийн хэвлэл, сонинуудад дэлгэрэнгүй нийтэлсэн байв.

Энэ мэдээ дэлхийд цацагдсаны улмаас ЭЗХТЗ-ийн гишүүн орны нөхөд ихэд гайхаж Монголд Японы хөрөнгө оруулалт орж ирэх нь гэж байлаа. Гэтэл ЗХУ-ын Гадаад явдлын яамны сайд А. Громыко манай Гадаад явдлын яамны сайд А. Ринчинд “Та нар Японтой их ойртох гэлээ, болохгүй” гэж хоригложээ.

Ингээд МАХН-ын Төв Хорооны Улс төрийн Товчоо Японы талын саналаар “сэтгэл санааны засамж” гэдэг нэрээр /дайны төлбөр гэж нэрлэхгүй/ жилдээ 1000 тн ямааны ноолуур, 200 тн тэмээний ноос боловсруулах хүчин чадалтай “Говь” үйлдвэрийг японы талаар бариулахаар шийдвэрлэж, бусад яригдсан байгууламжийг дараагийн ээлжинд үлдээсэн байна.

“Говь” үйлдвэрийн барилгыг монголын тал барьж, Японы буцалтгүй тусламжийн 17 сая ам.доллараар Японы тал барилгын зураг хийж, үйлдвэрийн тоног төхөөрөмжийг нийлүүлсэн байна.

Дээрх комисс, хорооны хуралдаан 1972, 1980, 1987 онд болж Монголын хүсэлтээр Япон Улсын Засгийн газар 1974 оноос Монголын барааг гаалийн хөнгөлөлттэй тарифт хамааруулах болж, 1980, 1989 онд Япон барааны үзэсгэлэнг Улаанбаатар хотод, 1984, 1992 онд Монгол барааны үзэсгэлэнг Токио хотод тус тус зохион байгуулсан байна.

1977 онд Монгол-Японы засгийн газар хооронд эдийн засгийн талаар хамтран ажиллах хэлэлцээр байгуулсан. Энэ хэлэлцээрийн үндсэн дээр Японы “Иточу” пүүс, Монголын “Комплекс төхөөрөмжийн импорт нэгдэл”-ийн хооронд МЯ-78-01 тоот гэрээ хийгдэж Улаанбаатар хотод жилдээ 1000 тонн ямааны ноолуур, 200 тонн тэмээний ноос боловсруулах “Говь” үйлдвэр байгуулагдаж, 1981 оны 8 дугаар сарын 25-нд ашиглалтад ороход дээд газрын шийдвэрээр Монгол-Японы эдийн засгийн комиссын дарга Гадаад худалдааны яамны нэгдүгээр орлогч сайд Ю. Аюуш, Японы Элчин сайд М. Акихо нар хоёр талын гэрээний биелэлтийг шалгаж, үйлдвэр хүлээн авах актад Монголын комплекс төхөөрөмжийн импорт нэгдлийн дарга, Японы Иточу пүүсийн орлогч дарга нар гарын үсэг зурж, үйлдвэрийг нээх ёслолын туузыг Ю. Аюуш, М. Акихо нар хайчилж, үйлдвэр ашиглалтад орж, үйлдвэрийн даргаар Б. Ёндонжамц томилогдож аайв.

Энэ үйлдвэр ашиглалтад орсноор Монгол Улс ямааны ноолуур, тэмээний ноосон бүтээгдэхүүнийг экспортлох болж, энэхүү бүтээгдэхүүний экспортод эзлэх хувийн жин байнга өсч ирсэн байна.

“Говь” нь одоо жилдээ 1000 тн ноолуур, 200 тн тэмээний ноос боловсруулах хүчин чадлаа дүүрэн ашиглаж, жилдээ 400 мянган сүлжмэл бүтээгдэхүүн үйлдвэрлэн 80 хувийг экспортод гаргаж байна. Энд 1500 хүн ажиллаж, энэ төрлийн дэлхийн 5

том үйлдвэрийн нэг болжээ.

“Говь” үйлдвэр одоо 10-аад үйлдвэр, цехээс бүрдсэн цогцолбор болсон бөгөөд ноолуураар нэхмэл үйлдвэрлэж, хувцас оёдог “Говь-2” үйлдвэрийг харьяандаа байгуулжээ. “Говь” нь 30 тэрбум төгрөгийн үндсэн ба эргэлтийн хөрөнгөтэй, жилдээ 20 гаруй тэрбум төгрөгийн борлуулалт хийж, улсын төсөвт 4-5 тэрбум орлого оруулж, үлэмж цэвэр ашигтай ажилладаг байна.

1988 оноос Монгол-оросын хамтарсан уулын баяжуулах “Эрдэнэт” үйлдвэрийн бүтээгдэхүүн болох зэс, молибдений баяжмалыг Япон Улсад экспортлох болсон, мөн урьд өгч, авч байсан бараануудаар худалдаа хийгджээ.

*1981-1989 онуудад хоёр орны хооронд хийгдсэн худалдааны нийт гүйлгээг үзүүлбэл:*

*/сая ам.доллараар/*

1981	1982	1983	1984	1985	1986	1987	1988	1989
4,5	9,79	4,75	12,08	9,58	9,78	9,0	30,4	30,5

1989 оныг 1981 онтой харьцуулахад нийт гүйлгээ 6 дахин өсчээ.

1990 онд Засгийн газруудын хооронд худалдааны хэлэлцээр байгуулагдаж, Японы талаас янз бүрийн машин, тоноглол, химийн бараа, будаг, эм, өргөн хэрэглээний бараа, Монголоос нэхмэл, нүүрс, уул уурхайн бүтээгдэхүүн, хагас үнэт чулуу, архи зэргийг нийлүүлэхээр хэлэлцээрт тусгаж, хоёр талдаа худалдааны тааламжтай нөхцөлийг үзүүлж, тооцоог чөлөөт валютаар хийнэ, худалдааг аль болохоор өсгөхөд чармайна гэж заасан боловч 1990 оноос Монгол орныг хамарсан эдийн засгийн гүнзгий хямрал болон тус улсын экспортын гол бүтээгдэхүүн болох ноолуур, зэсийн дэлхийн зах зээлийн үнэ буурсан нь хоёр орны хоорондын худалдаанд нөлөөлсөн ч, манай орны сонгож авсан ардчилал, зах зээлийн эдийн засагт шилжих замыг Япон Улын Засгийн газар, ард түмэн эхнээс нь тууштай дэмжиж, нийгэм, эдийн засгийн бүхий л салбарыг хамарсан зээл, тусламж олгох төслүүд хэрэгжүүлэх, худалдааны томоохон пүүсүүд нь төлөөлөгчийн газраа Монголд нээх, хөрөнгө оруулах зэрэг олон талын арга хэмжээ авч байгаа нь хоёр орны хоорондын худалдааг өсгөх нөхцөлийг бүрдүүлж байгаа боловч монголын экспортын зарим барааны дэлхийн зах зээлийн үнэ хэлбэлзэлтэй явж иржээ.

Монгол-Японы хооронд шууд нислэг хийгдэж, Японы жуулчдын тоо нэмэгдэж, хөрөнгө оруулалт ихсэж, Япон Улсаас манай улсад үзүүлж байгаа зээл тусламжийн хэмжээ тогтвортой байгаа, Японд зохиогдож буй үзэсгэлэн яармагт монголын аж ахуйн нэгжүүд тогтмол оролцож, бараа бүтээгдэхүүнээ су?талчилж байгаа зэрэг нь хоёр орны хоорондын худалдааг цаашид өсгөхөд чухал ач холбогдолтой болж байна.

1990-2000 оны Монгол-Японы худалдааны эргэлтийг сая ам.доллараар үзүүлбэл:

Он	1990	1991	1992	1993	1994	1995	1996	1997	1998	1999	2000
Экспорт	7,6	10,8	18,8	17,01	44,96	95,34	35,0	37,66	13,0	10,9	8,11
Импорт	10,0	2,76	40,05	20,76	16,66	45,26	77,8	34,67	59,25	115,02	68,52
Нийт	17,6	13,56	58,85	37,76	61,62	140,6	112,8	72,33	72,25	125,91	76,63

2001 онд Монголын экспорт 12,6 сая, импорт 52,8 сая, нийт эргэлт 65,4 сая ам.доллар болсон байна. Цаашид хоёр орны хоорондын худалдааны балансыг хатуу барьж худалдааг тэнцвэртэй хөгжүүлэх шаардлагатай байна.

*Японы зээл, тусламжийн талаар:*

Японы Засгийн газраас хөгжиж буй орнууд, ардчилал, зах зээлийн харилцаанд шилжиж буй орнуудын хөгжлийг дэмжих зориулалтаар олгодог тусламжийн нэр нь хөгжлийн албан ёсны тусламж буюу товчоор ХАЁТ гэдэг.

Монгол-Японы эдийн засгийн хамтын ажиллагааны тухай / "Говь" үйлдвэр барих тухай/ анхны хэлэлцээрийн дагуу Японы Засгийн газар 1977 онд 5 тэрбум иен /17 сая ам.доллар/-ий буцалтгүй тусламж олгосноос эхлэн Японы ХАЁТ-д Монгол Улс хамрагдах болсон байна. Энэ хэлбэрийн хамтын ажиллагаа 1990-ээд оноос идэвхжиж ирсэн байна.

Японоос монголд олгож ирсэн зээл, тусламжийг аж ахуйн салбараар гаргаж үзэхэд тээвэр, эрчим хүч, хүний хүчин зүйлийг хөгжүүлэх болон хөдөө аж ахуйн салбар бусдаасаа давамгайлж байна.

1993-1997 онуудад тээврийн салбарт хөрөнгө оруулалт эрчимтэй хийгдсэн бол 1997 оноос эрчим хүчний салбарын хөрөнгө оруулалт эрс нэмэгджээ. "Говь" үйлдвэр, Хархорины үр тарианы агуулах, сансрын холбооны газрын станц, Замын-Үүдийн сэлгэн

ачих байгууламж, Дарханы Махкомбинат, Улаанбаатарын Сүүний үйлдвэр, Улаанбаатарын 4 дүгээр дулааны цахилгаан станц, Шивээ-Овоо, Багануурын нүүрсний уурхай, хөдөөгийн сумдын дизель станцыг шинэчлэх, Төв аймгийн Эрдэнэ сумын орчим асфальт чулуун зам тавих, хүнсний бүтээгдэхүүнийг нэмэгдүүлэх, төмөр замын тээн нэвтрүүлэх чадварыг сайжруулах, нийслэл хотын нийтийн тээврийг сайжруулах, нэгдсэн 2 дугаар эмнэлгийн тоног төхөөрөмжийг шинэчлэх зэрэг нийгэм, эдийн засгийн салбарын томоохон төслүүд амжилттай хэрэгжсэн байна.

Техникийн хамтын ажиллагааны хүрээнд Монголоос 850 гаруй хүн Японд сурч, Японы 290 гаруй мэргэжилтэн, 90 орчим залуу сайн дурынхан манай улсад ажиллаж, хөгжлийн 25 судалгаа хийсэн байна.

Хоёр орны хооронд дипломат харилцаа тогтоосон 1972 оноос 2000 оныг дуустал хугацаанд 36,1 тэрбум иений хөнгөлөлттэй зээл, 56 тэрбум иений буцалтгүй тусламж, 19 тэрбум иений техникийн хамтын ажиллагааны тусламж олгосныг оноор /хүснэгтээр/ үзүүлбэл:

*Японы засгийн газраас Монголд олгосон зээл тусламж*

*/100 сая иенээр/*

Он	Буцалтгүй тусламж	Хөнгөлөлттэй зээл	Техникийн хамтын ажиллагаа	Дүн
1977	50,00			50,00
1978-1990	6,04		4,66	10,70
1991	33,08	48,36	4,02	85,46
1992	39,08	24,59	6,81	70,48
1993	45,35	33,21	18,10	96,68
1994	59,05	47,53	22,72	129,30
1995	58,25	44,93	23,37	126,55
1996	48,03	58,27	18,13	124,43
1997	50,46	42,98	19,33	112,77
1998	52,75		24,65	77,40
1999	53,56		24,43	77,99
2000	64,80	61,39	24,0	150,19
<b>Бүгд</b>	<b>560,63</b>	<b>361,26</b>	<b>189,79</b>	<b>1111,7</b>

2001 онд Парижын хандивлагчдын уулзалтаар Япон Улс манайд 118 сая ам.долларын тусалцаа үзүүлэхээр амласнаас зээл

63 сая, бусад нь техникийн хамтын ажиллагаа, тусламж болно.

Монголд сүүлийн жилүүдэд тохиолдож байсан байгалийн гамшгийн хохирлыг гэтлэн давахад Япон Улс, Японы ард түмэн үлэмжийн тусламж үзүүлж байлаа. Үүнд: 1993 онд баруун гурван аймагт учирсан байгалийн гамшиг болон 1996 оны хавар тохиолдсон ой, хээрийн түймрийн хохирлыг давахад зориулан Японы Засгийн газар тус бүр 100 мянган ам.долларын хүмүүнлэгийн яаралтай тусламж үзүүлсэн, мөн 1999 онд тохиолдсон зудын бэрхшээлийг давахад 50 мянган ам.долларын тусламж, 2000 оны 11 дүгээр сард 10 сая ам.доллар, 2001 оны 2 дугаар сард 3 сая ам.долларын тусламж олгожээ.

Өнөөдөр Япон Улсын тусламж аж ахуйн салбар, аймаг, сумдад хүрч байна.

### *Хандивлагчдын уулзалт-тусламж*

1990-ээд оноос Японы Засгийн газар, Японы ард түмэн Монгол орны эдийн засгийн хүнд байдлыг сайжруулахын тулд ихээхэн санаачилга гаргаж туслаж эхэлсэн бөгөөд ялангуяа Японы Засгийн газар олон улсын хамтын ажиллагааны хүрээнд манай улсыг идэвхтэй дэмжиж ирсэн. 1993 онд Токиод болсон тэргүүлэх хөгжилтэй орны дээд хэмжээний уулзалтын эдийн засгийн тунхаглалд Монгол Улсыг анх удаа нэр заан оруулснаар монголд хандивлагч орнуудын уулзалтыг Япон Улс Дэлхийн банктай хамтран 1991-2001 онд 8 удаа зохиожээ. Үүнд: Токиод 6 удаа, Улаанбаатарт 1 удаа, Парижт 1 удаа.

1991-2000 онд нийт хандивлагч орнууд 613,3 сая ам.долларын буцалтгүй тусламж амласнаас гүйцэтгэл нь 535,9 сая ам.доллар болсны дотор Япон Улс 427,8 саяыг амлаж 398,9 сая ам.доллар өгсөн нь нийт буцалтгүй тусламжийн 74,4 хувийг эзэлж байна.

Мөн эдгээр орнууд 688,2 сая ам.долларын техникийн хамтын ажиллагаа хэрэгжүүлэхээр амласнаас 458,1 сая ам.долларын тусламж хэрэгжжээ. Үүнээс Япон Улс 160,6 саяыг амлаж 190-ээд сая ам.долларын тусламж үзүүлж, амлалтаа 30 саяар давуулан биелүүлжээ. /Японы зээл тусламж гэдэг хүснэгтэд тусгагдсан болно/

2001 онд Парижид болсон хандивлагчдын зөвлөгөөнд оролцсон улсууд, Олон улсын банк нийтдээ 330 сая ам.долларын



тусламж амласны дотор Япон Улс 118 сая ам.долларын тусламж, зээл амлаж хандивлагч орнуудаас тэргүүн байрыг эзэлсээр байна.

Японы Засгийн газар, Дэлхийн банктай хамтран зохион байгуулсан хандивлагч орнуудын анхны уулзалтад 10 улс, олон улсын 5 байгууллага оролцсон бол дараагийн жилүүдэд оролцогчид нь өссөөр 2001 оны уулзалтад 18 улс, олон улсын 14 байгууллага оролцжээ. 2002 оны хандивлагчдын уулзалтыг 9 дүгээр сард Улаанбаатар хотноо хийхээр төлөвлөж байна.

Монгол-Японы найрамдалт харилцаа, үр бүтээлтэй хамтын ажиллагааг 21 дүгээр зуунд дараах зүйлүүдэд чиглүүлэн хамтран ажиллах нь:

1. Монгол Улс нь юуны өмнө үндэснийхээ үйлдвэрлэлийг сэргээн хөгжүүлж, хөгжил дэвшилтэд хүрэх урт хугацааны стратегийн төлөвлөгөөгөө боловсруулж, түүний дагуу боловсролын өндөр түвшинтэй, хөдөлмөрч ард түмэнтэй, шинжлэх ухаан-техникийн дэвшилттэй, эдийн засаг, санхүүгийн асар их нөөцтэй Япон Улстай түншлэлийн харилцаагаа улам өргөтгөн шинэ хэлбэр, агуулгаар баяжуулан хөгжүүлэх нь манай улсын тэргүүн зэргийн зорилгуудын нэг болж байна.

2. Өнгөрсөн хугацаанд Монгол Улс нь худалдааг өөрийн боломжоор хийж, ихэнхдээ Япон улсаас буцалтгүй тусламж, хөнгөлөлттэй зээл, техникийн хамтын ажиллагаагаар тусламж дэмжлэг авч ирлээ.

Цаашид худалдааг идэвхтэй хөгжүүлэхийн зэрэгцээ, эдийн засгийн хамтын ажиллагааг харилцан ашигтай хамтран ажиллах хэлбэрээр хөгжүүлэх нь зүйтэй байна.

Япон Улсын хөрөнгө оруулалтыг дараах зүйлд чиглүүлэх.  
Үүнд:

а. Мал аж ахуй, газар тариаланг эрчимтэй хөгжүүлэх, ялангуяа хөнгөн, хүнсний үйлдвэрийг хөгжүүлж, орчин үеийн технологийг монголд нэвтрүүлэх ашигтай төслүүдийг сонгон авч хэрэгжүүлэх. /Мах, махан бүтээгдэхүүн, арьс шир, ноос, ноолуур, бусад бүтээгдэхүүн боловсруулж эцсийн бүтээгдэхүүн хийж хоёр орны хэрэгцээг хангах/.

б. Монголын байгалийн баялгийг ашиглах хамтын ажиллагааг хөгжүүлэх /алт, мөнгө, зэс, төмрийн хүдэр, газрын тос, цайр, хар тугалга, молибден, вольфрам, коксжих нүүрс зэргийг аль болох хямд зардлаар олборлож, ашиглах/.

в. Байгал орчинг хамгаалах, ойжуулах, цөлжилтийг зогсоох, боловсон хүчин бэлтгэх, харилцаа холбоо, эрүүл мэнд, агаарын тээврийг тогтмолжуулан хөгжүүлэх, газар түрээсээр ашиглуулах зэрэг бусад ашигтай хэлбэрүүдийг хөгжүүлэх.

г. Аялал жуулчлалыг хөгжүүлэх

д. Монгол-Японы хоорондын найрсаг харилцааг аймаг, сум, хот тосгон, хувь хүмүүсийн хооронд идэвхтэй хөгжүүлж, ажил амьдралын арга туршлагаас суралцахад чиглүүлэх.

е. Өнөө үед дэлхийн бүх орон зах зээлийн эдийн засгийн хөгжлийн замаар тууштай хөгжиж байгаа нөхцөлд Монгол Улс өндөр хөгжилтэй монголд элэгсэг, найрсаг харьцаатай Япон Улс, Японы ард түмний өгөөмөр их тусламж дэмжлэгийг үр бүтээлтэй ашиглаж улсыноаа эдийн засгийг түргэн хөгжүүлж, ард түмний амьдралыг сайжруулах нь бид бүхний чухал зорилт болж байна.

#### АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. Монголын худалдаа аж үйлдвэрийн танхим. Хөгжил цэцэглэлтийн 40 жил-2000 он
2. Монгол Улсын статистикийн эмхэтгэл – 2000 он
3. Монгол-Японы харилцаа эрт, эдүгээ 2001 он
4. Өнөөдөр сонин, 2002.1.7-ны № 4.